



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР

**“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАЛТАД ӨРТӨХ, НИЙГМИЙН СӨРӨГ ХАНДЛАГЫН СУДАЛГАА”- НЫ
ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2021

Энэхүү судалгааны тайланг олон нийтэд мэдээлэх зорилгоор бүтээсэн бөгөөд тус судалгааны тайлантай холбоотой санал, хүсэлтийг бидэнд ирүүлэх, хамтран ажиллах боломжтой.

Хянасан:

Д.Ганболд /Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дэд дарга/

Ц.Нямсүрэн /Хөгжил, хөдөлмөрийн асуудал хариуцсан дэд дарга/

Б.Амаржаргал /Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөгжил, нийгмийн оролцооны газрын дарга/

Судлаач:Х.Сансармаа /Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөгжил, нийгмийн оролцооны газрын Хөгжлийн бэрхшээлийн судалгаа, эрдэм шинжилгээ хариуцсан мэргэжилтэн/

Агуулга

Удиртгал

Судалгааны арга зүй (дизайн)

Судалгааны үр дүн

Дүгнэлт

Санал зөвлөмж

Товчилсон үгийн тайлбар

Нэр томъёоны тайлбар

Хүснэгтийн жагсаалт

Загварын жагсаалт

Ном зүй

Хавсралт

УДИРТГАЛ

Хүн бүр боловсролын гадна үлдэх ёсгүй юм. Бүхий л боловсролын тогтолцоо нь сурагч бүрийг амжилтад хүрэх тэгш боломжоор хангах ёстой¹. Энэ боловсролын эрх тэгш байдлыг хангахын тулд Дакарын үйл ажиллагааны хөтөлбөр (2000)-т зааснаар ядуу, бие эрхтний, оюун ухааны хомсдолтой, ажил хөдөлмөр эрхэлдэг, алслагдсан хөдөө орон нутагт байгаа нүүдэлчин, дайнд нэрвэгдсэн, хүүхэд, өсвөр насныхан, жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн зэрэг боловсролоос тусгаарлагдах эрсдэлд өртөмтгий хүүхдүүдэд боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой төдийгүй сургууль завсардсан, суралцах боломжгүй хүүхдүүдийг боловсролд хамруулах үүднээс боловсролын тогтолцоог уян хатан болгох юм. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ын зорилт 4-т заасан чанартай боловсролыг дэмжих, зорилт 10-т заасан тэгш бус байдлыг бууруулах, улмаар зорилт 8 болон эдийн засгийн хөгжил, баталгаат ажлын байрыг бий болгох, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2.1.1-т Боловсролын чиглэлээр суурь болон хавсарга судалгааг тогтмол хийж хэвших ба бүх шатны боловсролын сургалтын байгууллагын байршил, хүчин чадал, нөөц, нормативын нэгдсэн зураглал, судалгаа, шинжилгээний мэдээллийн санг бий болгон, судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналт хийх, 2.1.11-т Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй эрсдэлд бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, удирдлагын тогтолцоог сайжруулах, 2.1.15-т Малчин, шилжин суурьшигч, орлого багатай өрхийн ялгаатай болон тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол тэгш олгох боломж, орчин нөхцөлийг бүрдүүлж, эцэг эх, асран хамгаалагчдыг чадавхжуулах замаар тэдний оролцоонд түшиглэсэн хүүхдийн хөгжлийг дэмжинэ гэж тус тус заасан нь нэн чухал. Үүний тулд ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн² боловсролын хүртээмж, чанарт анхаарах нь зайлшгүй. Тухайлбал, эмзэг бүлгийн (нийгэм-эдийн засгийн) хүүхэд гэдэгт 18-аас доош насны, хангалттай халамж, анхаарал, хамгаалал хүртэж чадахгүй, эрсдэлд нөхцөлд байгаа тухайлбал, эцэг эх нь орхисон, туйлын ядуу нөхцөлд амьдардаг, хөгжлийн бэрхшээлтэй, эцэг, эх, асран хамгаалагчдын зүгээс хүчирхийлэл үзүүлдэг, ялгаварлан гадуурхалтад өртсөн байдалтай зэрэг хүүхдүүдийг хамааруулдаг байна.

¹OECD (2020). *How's Life? 2020: Measuring Well-being-Highlights*. Paris. Retrieved from <https://www.oecd.org/sdd/How-is-Life-2020-Highlights.pdf>

² БСШУСЯ GPE WB (2019). *Монгол Улсын бага боловсролын салбарын судалгаа тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот. UNESCO SDG GEMR (2016). *Хүмүүс, гараг дэлхийн төлөө боловсрол: Бүх нийтийн төлөө тогтвортой ирээдүйг бүтээх нь. Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлангийн хураангуй*. Монгол Улс, Улаанбаатар хот.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрч, ялгаварлан гадуурхалтыг арилган тэгш боломж бүрдүүлэх тухай онцгойлон дурдаж, энэхүү зорилгод чиглэсэн тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бий болгох, Ази, номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бага, дунд сургуульд хамрагдалтын тоог нэмэгдүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6.3.3-д хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, ялгавартай хандахаас зайлсхийх талаар тус тус заасан.

Үндэсний статистикийн хорооны 2020 оны албан ёсны тайланд дурдсанаар Монгол Улсын хүн амын 3.3 хувь (108,399) нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй, тэдгээрийн 10,6 орчим хувийг (11,495) 0-17 насны хүүхэд эзэлж байна. 2020-2021 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 1156, ерөнхий боловсролын сургуульд 5628 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцаж байгаа бөгөөд энэ нь нийт хамрагдах ёстой хүүхдүүдийн 62.5 хувийг эзэлж байна. Үүний цаана сургуульд хамрагдаж чадахгүй хүнд хэвтрийн асаргаа шаардлагатай олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна. Энэ нь ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургахад сургалтын хүртээмжтэй орчин бүрдээгүй, тэдэнтэй ажиллах багш, мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдал, хамгийн гол нь ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх нийгмийн хандлага бүрдээгүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуулийн орчинд ялгаварлан гадуурхалтад өртсөөр байгааг харуулж байгаа юм. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрх нь нийгмийн сөрөг хандлагаас болж хэрхэн зөрчигдөж буй бодит байдалд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох нэн шаардлагатай байна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ (ДИЗАЙН)

Судалгааны зорилго:

Боловсролоос тусгаарлагдсан ялгаатай хэрэгцээтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын тулгамдсан асуудал, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тайланг холбогдох газарт танилцуулах

Судалгааны зорилтууд:

- Боловсролоос тусгаарлагдсан ялгаатай хэрэгцээтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын хэрэгцээг судлах хэрэгцээ, шаардлагыг онол, арга зүйн төвшинд тодорхойлох

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалт, тулгамдсан асуудал, нөхцөл байдлын талаарх 3-аас доошгүй судалгааны тайлан, илтгэлд дүн шинжилгээ хийх
- Судалгааны үр дүнг баримтжуулах тоон болон чанарын мэдээлэл цуглуулах
- Дүн шинжилгээний үндсэн дээр тайлан гаргаж, олон нийтэд танилцуулах

Судалгаанд оролцогч талууд, арга, судлах зүйл:

Судалгааны мэдээлэл цуглуулахад хэрэглэсэн арга зүйг хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогч талууд, судалгааны арга, судлах зүйл

	Судалгаанд оролцогч талууд	Судалгааны арга	Судлах зүйл
1	Судлаач	Баримтын бичгийн судалгаа (Статистик тоо баримт, хууль эрх зүйн баримт бичиг, хөтөлбөр, судалгааны тайлан, ерөнхий боловсролын 1 сурах бичигт дүн шинжилгээ хийх)	Онолын үзэл баримтлал, судлах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох 3-аас доошгүй судалгааны тайлан, илтгэлд дүн шинжилгээ хийх
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ТББ	Уулзалт, ярилцлагын асуултын чиглэл (Загварыг Хавсралт 1-ээс үзнэ үү)	Судалгааны үр дүнг баримтжуулах тоон болон чанарын мэдээлэл цуглуулах
3	Судлаач, ажлын хэсэг	Баримт бичгийн судалгаа	Тайлан бичиж, холбогдох газарт танилцуулах

Зохион байгуулагч:

ХБХХЕГ-ын Хөгжил, нийгмийн оролцооны газар

Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт:

Судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролд тэгш хамруулах талаарх онолын үзэл баримтлал, судлах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор нийт 20 олон улсын болон дотоодын судалгааны материалд дүн шинжилгээ хийв. Судалгааны үр дүнг баримтжуулах тоон болон чанарын мэдээлэл цуглуулах зорилгоор Фокус бүлгийн ярилцлагыг цахимаар 2 удаа зохион байгуулж, нэг удаагийн фокус бүлгийн ярилцлага 90-120 минут үргэлжилсэн ба нийт 35

хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, төрийн бус байгууллагуудын мэргэжилтэн, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан нар оролцов. Фокус бүлгийн ярилцлагыг олон нийтэд нээлттэй ZOOM APP ашиглан ХБХХЕГ-ын facebook page хуудсаар дамжуулан зохион байгуулсан болно.

Судалгааны үр дүн:

Хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, ялгавартай хандахаас зайлсхийх талаар бодлогын санал зөвлөмж боловсруулахад судалгааны тайлан нь хувь нэмэр үзүүлэх болно.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах, ялгаварлан гадуурхалтаас ангид байхад чиглэсэн хууль, эрх зүйн орчин, нөхцөл байдал:

Монгол Улс 2009 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцыг соёрхон баталж, энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн хэрэгцээт үйлчилгээг авах, бусдын нэгэн адил амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхээ эдлэх явдлыг хангахын тулд 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж байна. Эдгээр хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрч, алагчлалыг арилган тэгш боломж бүрдүүлэх тухай онцгойлон дурдаж, энэхүү зорилгод чиглэсэн тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бий болгох, Ази, номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Эрхийг бодит болгоё Инчеоны стратегид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бага, дунд сургуульд хамрагдалтын тоог нэмэгдүүлэхийг тэргүүлэх зорилт болгон тусгажээ. Дээр дурдсан олон улсын конвенц, хамтарсан тунхаглал, хуулийг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улс ч тодорхой хүчин чармайлт гарган ажиллаж, Монгол Улсын Их хурлын 2018 оны 56 дугаар тогтоол, Засгийн газрын 250 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжил, хамгааллын талаарх Засгийн газрын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, салбар дундын зохицуулалт хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, бие даан хөгжих чадварыг сайжруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар байгуулагдан ажиллаж байна (ХНХЯ & JICA, 2019).

Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн хоёрдугаар бүлгийн 16-р зүйлийн 7-д хүн бүр сурч боловсрох эрхтэй ба төрөөс ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгох, Боловсролын тухай хууль (2002)-ийн 5.1.4-д зааснаар хөгжлийн бэрхшээлийн онцлогоос болж ялгаварлан гадуурхахгүй байх, сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангах, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.1.3-т бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг тусалцаа үзүүлэх, Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, бүх шатны боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах асуудлыг тусгасан байдаг. Мөн 2019 оны А/292 тогтоолын нэгдүгээр хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамрах сургах журмыг баталсан. Энэхүү журамд заасны дагуу сургууль нь нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын

хамтран баталсан зааврын дагуу сум, хорооны сургуульд хамрагдалтын дэмжих зөвлөлтэй хамтран ажиллана гэж заасан байдаг.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/184 тушаалын хавсралтаар Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам, 2018 оны А/155 тушаалаар тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай суралцагчдын хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэг үзүүлэх бүхий ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал зэргийг батлан хэрэгжүүлж байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор БСШУСЯ, МУБИС-ийн дэмжлэгтэйгээр 2017 оны 12 дугаар сарын 06-нд Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим байгуулагдан, 2013-2019 онд 1 жилийн бакалаврын хөрвөх сургалтаар 113, 2019 онд 3,5 жилийн бакалаврын сургалтаар 9 оюутан төгссөн байна. 2018-2019 оны хичээлийн жилд БСШУСЯ санаачилга гарган Монгол Улсад 20-иод жил тасалдаад байсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах согог зүйч мэргэжлийн багшийг бэлтгэх ажлыг сэргээж ОХУ-ын Эрхүүгийн их сургуульд тусгай боловсролын мэргэжлийн 10 багш бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн багш мэргэжлийн ангийн сонгон судлах хичээлийн жагсаалтад тусгай хэрэгцээт боловсролын 2кр хичээл орсон бөгөөд өнгөрсөн хугацаанд МУБИС-ийн харьяа 4 салбар (СӨБС, НХУС, БУС, БТС) сургуулийн нийт 1060 оюутанд ТХБ-ын тэнхимийн 3 үндсэн, 5 гэрээт багшийн бүрэлдэхүүнтэйгээр сургалтын үйл ажиллагаа явуулж үйлчилгээ үзүүлсэн байна (Батцэнгэл & Байгалмаа, 2018; Батцэнгэл, 2020).

2012 оноос Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институтэд тусгай хэрэгцээт боловсрол хариуцсан арга зүйчийн бие даасан орон тоо бий болсон нь сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтнуудад тусгай хэрэгцээт боловсрол, тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр багшийн хөгжлийг дэмжих нөхцөл бүрдсэн ба сургуулийн захирлуудын тушаалаар дэмжлэгийн багийг байгуулж, сум, хорооны сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлтэй хамтран ажиллаж, тусгай сургуулиудаас мэргэжил, арга зүйн дэмжлэг авч, хамтран ажиллаж байна (Жаргал, 2018).

2016 онд Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.2.1-д заасны дагуу 0-16 насны хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс тогтооно гэсний дагуу комиссын үйл ажиллагаа явагдаж эхэлсэн. 2017 оны байдлаар аймаг, дүүргийн салбар комиссууд нийт 3949 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг, 3487 хүүхдэд байнгын асаргаа шаардлагатай болохыг тодорхойлж, 239 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд, 314 хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд, 11 хүүхдийг

боловсролын бусад үйлчилгээнд холбон зуучилж, хамруулсан байна (ХНХЯ & JICA, 2019).

Мөн Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8.14-т зааснаар сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч тусгай мэргэжлийн багш, туслах багш, эмч, сэргээн засалч, нийгмийн ажилтан ажиллуулж болно гэж зээсэн байдаг.

Боловсролын салбарт 2018 оны байдлаар ДНБ-ийн 5 хувь ба улсын төсвийн зарлагын 15.3 хувийг зарцуулдаг хэдий ч 80 орчим хувийг урсгал зардалд зарцуулдаг тул боловсролын үйлчилгээг сайжруулахад чиглэсэн ялгаатай хэрэгцээтэй, эрсдэлд өртөмтгий хүүхдүүдийн сургалтын орчинг сайжруулах, шаардлагатай тохируулгатай техник хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүн, анги танхимын засвар үйлчилгээ, сургалтын таатай орчны нөхцөл бүрдүүлэхэд санхүүжилт хийгдэхгүй байна.

Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл, сургууль доторх дэмжлэгийн багийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай боловсон хүчнийг ажиллуулах цалин урамшууллын асуудал шийдэгдээгүй, хэн ажиллах нь тодорхой бус, ажиллах боловсон хүчний хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах мэргэжил, арга зүйн ур чадвар хангалтгүй бөгөөд энэ асуудал нь зөвхөн боловсролын салбарын асуудал биш төдийгүй салбар дундын зохицуулалт хийж тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай асуудал юм.

Судалгаанд оролцогчдын хариулт, уулзалтын үр дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг хангах, тэднийг боловсролоос ялгаварлан гадуурхалтад өртүүлэхгүй байхад чиглэсэн хууль эрх зүйн тодорхой тооны баримт бичгүүд байгаа хэдий ч олон нийтийн тэгш хамруулах үзэл санааны ойлголтын зөрүүтэй байдал, сургуульд хамрагдалтын дэмжих зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй, сургуулийн удирдлага, ажилтнуудын хууль эрх зүйн талаарх мэдлэг дутмаг, санхүүгийн тогтолцоо хангалттай бус зэрэг байдлуудаас болж үр дүнтэй хэрэгжихгүй байгаа юм байна. Иймд хуулийн хэрэгжилтийг хангах механизм, журмыг тодорхой болгох, сургуулийн удирдлага, олон нийтийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролоос ялгаварлан гадуурхалтын талаарх ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангахад салбар хоорондын уялдаа, холбоог сайжруулж ажиллах шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалтын өнөөгийн нөхцөл байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.3.1-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн бэрхшээлээс нь үл хамааран бүх шатны боловсролын байгууллагад бүрэн хамруулна. Бага дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т зааснаар 6 нас хүрсэн хүүхэд ерөнхий боловсролд сургуульд элсэж орно гэсний дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

мөн адил хамрагдах ёстой. 2020 оны байдлаар Монгол Улсын хүн амын 3.3 хувь (108,399) нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй, тэдгээрийн 10,6 орчим хувийг (11,495) 0-17 насны хүүхэд эзэлж байна. Үүнээс 2020-2021 оны хичээлийн жилд Сургуулийн өмнөх боловсролд 1156 хүүхэд, Ерөнхий боловсролын сургуульд 5628 хүүхэд суралцаж байгаа бөгөөд энэ нь нийт сургуульд хамрагдах ёстой хүүхдүүдийн 60 орчим хувийг эзэлж байна.

Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан төрийн өмчийн 2 тусгай цэцэрлэг (186, 10), аймгийн төвүүд дээр хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хувийн хэвшлийн цэцэрлэгүүд, мөн төрийн өмчийн ердийн цэцэрлэг дээр тусгай бүлгүүд ажиллаж байна.

Монгол Улсад 1964 оноос хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан төрийн өмчийн 6 тусгай сургуулиуд (25, 55, 63, 70, 29, 116) үйл ажиллагаа явуулж байгаа ба үүнд нийт хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын ойролцоогоор 1500 сурагчид нь хамрагджээ (2020 оны байдлаар).

Дээрх тоон мэдээллүүдээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалт хангалтгүй, тэр дундаа хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын гадна үлдэж байгаа нь (Сарантуяа, 2018; Sansarmaa, 2018; БСШУСЯ, ADB, Японы ядуурлыг бууруулах сан, 2019) эдгээр хүүхдүүд боловсролоос ялгаварлан гадуурхалтад өртөж буйн илрэл мөн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн цэцэрлэгт суралцах, нэмэлт туслалцаа дэмжлэг авах бололцоо хангалтгүй (WB, 2016), сургууль, цэцэрлэгийн удирдлага, багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүй дутмаг, тэдэнтэй ажиллахаас төвөгшөөн мөн сургалтын орчин бүрдээгүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг элсүүлэх дургүй байна. Эцэг эхчүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ сургууль, цэцэрлэгт зөөвөрлөх зам талбай байхгүй, зөөвөрлөх тээврийн хэрэгслийн асуудлын улмаас, ялангуяа өвлийн хүйтэнд зузаан хувцастай хүүхдээ зөөж хүргэж чадахгүйн улмаас цэцэрлэгээс хүүхдүүдээ гаргах асуудал түгээмэл байна. Нөгөө талаас эцэг эх, асран хамгаалагч нар өөрсдөө хүүхдээ 11, 12 нас хүртэл нь гэртээ байлгах сонирхолтой эцэг эхчүүд цөөнгүй байна. Эдгээр асуудлууд нь нийгмийн ойлголт хандлага сөрөг, сэтгэл дутмаг, илт ялгаварлан гадуурхалтын тод жишээнүүд мөн.

Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийнхээ нөөц, авьяас сонирхлыг нь илрүүлж, түүнд түшиглэсэн боловсролыг тухайн насанд нь өгч чадах бүрэн боломжтой гэдгээ мэдэхгүй, хүүхдийнхээ хөгжлийн хоцрогдлыг багаас нь эрт илрүүлэн хоёрдогч хүндрэл үүсэхээс нь өмнө засан сайжруулах, хөгжих боломжийг бий болгох, хүүхдээ боловсролд хамруулахгүй байна гэдэг нь эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдэдээ үзүүлэх ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр гэдгийг ойлгох хэрэгтэй байна. Иймд сургууль, цэцэрлэгийн удирдлага, багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүйг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлог хэрэгцээнд тохирсон сургалтын орчин

бүрдүүлэх, гудамж талбай, тээврийн хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдэдээ хандах хандлагыг эерэгжүүлэх шаардлагатай байна.

Тохиолдол 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт үеийн онолшилгооны талаарх эцэг эхийн мэдээлэл хангалтгүйн улмаас хүүхдээ шууд сургуульд авчирч ирж байна. Сүүлийн хоёр жилийн байдлаар 29 сургууль, 116 сургуулиуд сургуульд бэлтгэгдээгүй өөрөөр хэлбэл биологийн нас 6, хөгжлийн нас нь 2, 3 настай хүүхдийн хөгжлийн төвшинтэй адил чадвартай хүүхдүүдийг шууд авахгүй байгаа. Сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангасан, ядаж харандаагаа бариад сурсан хүүхдүүдийг сургуульд сургах асуудал гарч байна³.

Тохиолдол 2. Тэгш хамруулна гэдэг нь олон хүүхэд дунд хоёр хүүхэд шидчихээд тэгш хамрагдалт хангагдаж байгаа явдал биш. Хамгийн гол нь тэгш хамруулахад хүүхдийг сурах таатай орчинг нөхцөлийг бүрдүүлэх сургуулийн, гэрээс сургууль, сургуулиас гэр хүртэлх, анги, хамт олны орчныг бүрдүүлж, эдгээр хүүхдүүдтэй харилцах боловсон хүчин, дэд бүтэц, хүртээмж, багш, сурагчид, удирдлагуудын хандлага, эцэг эхийн мэдээлэл, оролцооноос хамаарах асуудал юм⁴.

Тохиолдол 3. Цэцэрлэг, сургуулиудын удирдлагууд өөрт байгаа орон тооны багш, ажилчдыг чадавхжуулах, нөгөө талаас практик туршлагатай боловсон хүчнүүдийг ажиллуулах ажлын байрны хомсдол байна. Өөрөөр хэлбэл, нэмэлтээр багш авах багшийн цалингийн асуудал шийдвэрлэгдээгүй, төсөвлөгдөхгүй байна. Ялангуяа хөдөө орон нутагт багш нарыг авч ажиллуулах орон тоо байхгүй тул энэ тал дээр улсаас зохицуулалт хийж өгөх, бодлогоор шийдвэрлэх шаардлагатай байна⁵.

Тохиолдол 4. Улаанбаатар хотод байрлах улсын цэцэрлэг, сургуулиудын хувьд бүх хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хамруулахад хангалттай багтаамж орон зай байхгүй юм. Иймд хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг

³ Судалгаанд оролцогч мэргэжилтний ярианаас (2021)

⁴ Судалгаанд оролцогч мэргэжилтний ярианаас (2021)

⁵ Судалгаанд оролцогч мэргэжилтний ярианаас (2021)

авч суралцуулах боломжтой сургууль, цэцэрлэгүүдийг бий болгох шаардлагатай байна⁶.

Судалгаанд оролцогчдын хариулт, уулзалтын үр дүнгээс харахад тэгш хамруулах үзэл санааны ойлголтын зөрүүтэй, сургуульд хамрагдалтын дэмжих зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй, ажилтнуудын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага мэдлэг дутмаг, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хичээлийн хэрэглэгдэхүүн, техник тоног төхөөрөмж хангалтгүй, багш, эцэг эх, сурагчид, олон нийтийн ойлголт хандлага дутмаг, сургуулийн орчны хүртээмжгүй байдал зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролоос ялгаварлан гадуурхагдахад хүргээд зогсохгүй нийгмээс тусгаарлаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын боловсролын чанарын асуудал, нөхцөл байдал:

Бие махбод, оюун ухаан, сэтгэл мэдрэхүйн онцлог байдал, нийгэм, сэтгэл зүй зэрэг бусдаас ялгаатай ямар нэг нөхцөл байдлаасаа үл хамааран хүүхэд бүр сургуульд хамрагдах боломжтой байх явдал бөгөөд түүнд хөгжлийн бэрхшээлтэй ба авьяаслаг хүүхдүүд, хараа хяналтгүй ба ажил хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, алслагдсан ба нүүдэлчин өрхийн хүүхдүүд, хэл, соёл ба үндэсний цөөнхийн хүүхдүүд болон бусад ялгаварлан гадуурхагдсан бүлгийн хүүхдүүд бүгд сургуульд хамрагдах ёстой гэж Саламанкагийн тунхаглал (1994)-д заасны дагуух боловсролын тэгш боломжийн үзэл санаа алдагдсан, тэр дундаа боловсролын чанарын асуудал хангалтгүй байгаа талаар судалгаанд оролцогчид хариулжээ. ЮНЕСКО-ийн Инчеоны тунхаглал 2030-д боловсролын тогтолцооны үр өгөөжийг хэмжих үзүүлэлт нь боловсролын чанарын асуудал ба түүнийг суралцагчдаас авсан тестийн гүйцэтгэл ба сурлагын амжилтаар үнэлэх гэж заасан байдаг (UNISEF, 2019). Мөн боловсролын салбарын 2019 оны суурь тайланд тэмдэглэсний дагуу боловсролын салбарт хүний хөгжлийн чиглэлээр баримтлах төрийн бодлогын үндэс, суурь болох боловсролын чанарын суурь судалгаануудыг хийх шаардлагатай байгаа юм (БСШУСЯ, БХ, & UNESCO, 2019). Тэр ч утгаараа Монгол Улсын засгийн газар боловсролын салбарт баримтлах хөгжлийн бодлогыг тодорхойлж, Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө 2021-2030-д иргэдэд чанартай боловсролоор амьдралын чанарыг бэхжүүлэх бүх нийтийн тэгш, хүртээмжтэй боловсролын хөгжлийн төлөвлөлтийг төлөвлөсөн төдийгүй 2021 онд Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага [OECD]-аас зохион байгуулдаг Олон улсын сурагчдын үнэлгээний хөтөлбөр [PISA]-д хамрагдахаар төлөвлөсөн байна (БСШУЯ, ADB, & ЯБЯС, 2019).

Дэлхий даяараа глобалчлагдаж, улс төр, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд өмнө нь хэзээ ч байгаагүйгээр янз бүрийн харилцан хамааралтай хямралд


⁶ Судалгаанд оролцогч мэргэжилтний ярианаас (2021)

өртөж байгаа энэ цаг үед аливаа эрсдэлийг даван туулах, дэлхийд өрсөлдөх чадвартай боловсролын тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай ур чадварыг эзэмшсэн хувь хүн бидэнд хэрэгтэй болоод байгааг харуулж байгаа юм (Prince-Embury, 2014). Тэгвэл олон улсад аль хэдийнээ Олон Улсын Сурлагын Амжилтын Үнэлгээний Холбоо (EIA)- ны Олон улсын математик болон шинжлэх ухааны судалгааны төв [TIMSS], OECD-PISA, мөн Зүүн Азийн орнуудын судлаачид аливаа саад бэрхшээлийг даван туулж, тууштай чадвар гарган сурлагын амжилт үзүүлж буй ялгаатай хэрэгцээтэй сурагчдыг [RS] илрүүлэх замаар боловсрол дахь тэгш бус байдлыг үнэлэх буюу олон улсын боловсролын тогтолцоонуудын чанарт дүн шинжилгээ хийж, түүнд нөлөөлж буй нийгэм-сэтгэл зүйн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, харьцуулсан судалгаануудыг эрчимжүүлж, бодлого, шийдвэрүүдийг тодорхойлж байна. Гэтэл өнөөдөр Монгол Улсын хувьд Боловсролын үнэлгээний төвөөс явуулдаг боловсролын чанарын үнэлгээний судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хамруулж судалдаггүй нь бас нэгэн ялгаварлан гадуурхалтын хэлбэр юм. Нэг үгээр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хөнгөрүүлсэн тест, тусгай шалгалт гэж байх ёсгүй бөгөөд хүн ямар байхаас үл хамааран бүхий л хүүхдүүд бусдын нэгэн адил нийгэмдээ өрсөлдөх чадвартай боловсон хүчин болж боловсролын тогтолцоогоор бэлтгэгдэх ёстой. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурсан мэдсэн зүйлээ бусдадаа гайхуулах, тэдний сурлагын амжилтыг үнэлэх, таниулахад чиглэсэн тохируулгатай нөхцөлийг бий болгох шаардлагатай юм.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх үзэл баримтлалын асуудал:

Хөгжлийн бэрхшээлийг хувь хүний асуудал гэж үзэн хувь хүнд асуудал нь байгаа бөгөөд тухайн хүнийг бид өөрсдийн нэгэн адил гадаад төрх, өнгө аястай болгох гэж өөрчлөх, тохируулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө өөрчлөгдөх ёстой, хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж хэрэгтэй гэж хардаг байсан хувь хүний загвараас бид нийгмийн загварлуу шилжиж, 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиндаа концепцын өөрчлөлтийг хийсэн юм.

Загвар 1. Анагаах ухааны загвар ба нийгмийн загварын ялгаа



Өнөөдөр бид юу гэж харж байна гэвэл хөгжлийн бэрхшээл нь хаана байна вэ? гэвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг эрхээ эдлэх боломж, нөхцөлийг хязгаарлаж буй нийгэм-орчинд нь байна гэж харах болсон. Нийгэм өөрөө өөрчлөгдөх ёстой юм. Өөрөө хэлбэл саад, бэрхшээл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тойрсон эргэн тойронд байгаа буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрхээ эдлэх эрхтэй бөгөөд түүнийг эрхээ эдлэхэд шаардагдах нийгэм-орчныг бүрдүүлж өгөх нь чухал юм.

Тохиолдол 5. Тэргэнцэртэй иргэн гэрээсээ гараад гудамжаар аюулгүй, бие даан явах гэтэл лифт алга, аюулгүй зам талбай алга, ажилдаа орлоо гэхэд налуу зам алга, хамт олон дунд орох гэхэд хамт олны уур амьсгал, хандлаг сөрөг байгаа зэрэг нь нийгмийн зүгээс үзүүлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлж ялгаварлан гадуурхалт мөн.

Загвар 2. Нийгэм-орчны саад бэрхшээл



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг багаас нь эрт үед нь аливаа асуудлыг даван туулах сэтгэл зүй, зан үйлийн чадвартай, танин мэдэхүйн ур чадвартай, сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлсэн дэд бүтэц, сургалтын орчин, эцэг эхийн харилцаа хандлагыг эерэгээр бүрдүүлж чадсан бол тэр хүүхэд өнөөдөр хэний ч туслалцаагүйгээр бүрэн дүүрэн бие даан суралцах чадвартай болох юм.



Загвар 3. Нийгмийн загвар


Тиймээс саад бэрхшээл нь:

- Эцэг эх, эцэг эхийн мэдээлэл дутмаг
- Харилцаа хандлага сул
- Сургуулийн орчин дэд бүтэц
- Боловсон хүчин
- Нийгмийн хөгжил гэх мэт.

Ийнхүү 2016 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэнэ гэж хөгжлийн бэрхшээлийг хөгжлийн бэрхшээлтэй хүний үйлдлийг хязгаарлаж буй саад бэрхшээл болох нийгэм-орчинд нь байна гэж хуульд өөрчлөлт оруулсан явдал нь ялгаварлан гадуурхалтын эсрэг томоохон арга хэмжээ болсон.

Энэхүү нийгмийн загварын гол мөн чанар нь нийгмийн саад тотгорыг арилгах буюу нийгмийн сэтгэлзүй, хандлагыг өөрчлөхийн тулд хамруулан хөгжүүлэх арга зам юм. Хамруулан хөгжүүлэх арга зам нь Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлага буюу CBR-Towards Community-based Inclusive Development Matrix зарчмаар хэрэгжих бөгөөд тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, нийгэм, хөдөлмөрөөр нь сэргээн засах явдал юм.

Загвар 4. CBR матриц



Үүний тулд тухайн хүний зан үйл, бэрхшээлийг эмчлэхээс илүү эрхийг нь хүндэтгэж, эрхийг нь хэрэгжүүлэхэд бодитой болгох нөхцөлийг бүрдүүлэх, түүнийг хэвийн хүнтэй адил тохируулах бус хөгжлийн ялгаатай, өөр байдлыг нь хүлээн авч, нийгмээс гадуурхах бус хамруулан оролцуулж, зааж зааварлах, зөвлөх бус хамтдаа чиглүүлж, туслах буюу бидний оролцоо чухал гэдгийг харуулж байж хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бид нийгмийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах асуудал юм.

Загвар 5. Эрхийг хүндэтгэх ялгаа

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сэргээн засалт

Нийгмийн сэргээн засалт

Зан үйл, АУ эмчилгээ		Эрх
“Хэвийн”- тохируулах		Өөр байдлыг хүлээн авах чадвар
Гадуурхах		Хамруулах, оролцуулах
Зөвлөгөө		‘Бидний оролцоо чухал’

CBR гол зарчим нь:

- Ялгаварлан гадуурхагдаж байгаа хэн бүхнийг хамруулан хөгжүүлэх, тэгш боломжоор хангах INCLUSIVE, EQUITY
- Хүний эрх- сурч боловсрох, хоол хүнс, орон байраар хангагдаж, тохирох нийгмийн хамгаалал хүртэх эрхтэй гэсэн үзэл санаа дээр тулгуурладаг.

CBR түүхэн замнал:

- 1978- Бүх нийтээрээ эрүүл байх (ДЭМБ-ын Алма-Атагийн тунхаглал)
- 1989- Хөгжлийн бэрхшээлтэй хүн, гэр бүлийн гишүүд, сургуулийн багш нар, орон нутгийн зохицуулагч, хамт олны сэргээн засах хүмүүс дэмжлэг үзүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд нь сургах гарын авлагыг боловсруулсан.
- 1990- Салбарын хандлагад өөрчлөлтүүд орсон (ЮНЕСКО, ЮНИСЕФ, ОУХБ)
- 1994- Хамтарсан бичиг баримт гарсан (ОУХБ, ЮНЕСКО, ДЭМБ)- ХОТСЗ матриц

- Ази, номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Эрхийг бодит болгоё Инчеоны стратеги (2012)

Монгол Улсын хувьд Ази, номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Эрхийг бодит болгоё Инчеоны стратеги (2012)-ийг Засгийн газар 2013 хүлээн авч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулган зохион байгуулан, улмаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7 дугаар бүлэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ, үйлчилгээ эрхлэх, үйлчилгээний хөтөлбөр гэсэн заалтуудыг тусгасан нь ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах томоохон хууль эрх зүйн баримт бичиг болсон.

Тохиолдол 6. Нэгэн багш сургуульд ажилд орох өргөдөл гаргажээ. Хувь хүний загвараар буюу бэрхшээлийг хувь хүнд байна гэж харвал уучлаарай, та манай сургуульд цаашид ажиллах боломжгүй, бид таны өрөөг солих боломжгүй, таныг шатаар дээш гаргах арга бидэнд байхгүй, та тэргэнцэртэй учраас цаашид манайд ажиллана гэж байхгүй үздэг байна. Хэрвээ нийгмийн загвараар бэрхшээлийг нийгэм, хамт олондоо байна гэж харвал та багшлах ур чадвартай сайн багш учраас бид таны ажиллах нөхцөлийг бэлдэж өгнө, бид таны өрөөг нэг давхарт шилжүүлж өгье, танд дээш гарах шаардлага гарахгүй, бид орон нутгийн засаг захиргаанаас бидэнд цахилгаан шат хийж өгөх боломжийн талаар, мөн сургуульд ээлтэй орчин бүрдүүлж өгөх хөтөлбөрийн талаар асуух болно гэж үздэг байна⁷.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролоос ялгаварлан гадуурхалтад өртөж буй нь сургууль завсардалтын шалтгаан нөхцөл болж байна:

Боловсрол, шинжлэх ухааны яамны статистик мэдээллийг илүү тодруулбал, 2015-2018 оны хичээлийн 3 жилийн хугацаанд сургууль завсардсан нийт сурагчдын дийлэнх шалтгааны 30 гаруй хувь нь өвчний улмаас, 10 гаруй хувь нь амьдралын гачигдлаас болсон байна (ҮСХ, 2018).

“Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” чанарын судалгааны тайлангаас үзэхэд хүүхдүүдийн сургууль завсардахын нэг шалтгаан нь биеийн гаднах төрх байдал, бусдаас ялгаатай

⁷ Х.Сансармаа (2021). *Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага сэдэвт лекцийн материал*. Монгол Улс, Улаанбаатар хот.

байдал гэжээ⁸. Биеийн гаднах төрх байдал, бусдаас ялгаатай байдлаас болж үе тэнгийнхний зүгээс шоолуулах, элдвээр доромжлуулах нь тухайн хүүхдийг сургуулиа орхиход шууд нөлөөлдөг байна. Энэ нь олон нийт, сурагчдын дундах хөгжлийн бэрхшээлийн талаарх сөрөг ойлголт, хандлагатай холбоотой бөгөөд нөгөө талаас сургуулийн удирдлага, багш, эцэг эхчүүдийн зүгээс хүүхдэдээ өгөх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухайн ойлголт, мэдлэг өгөх ажил учир дутагдалтай байгаагийн илрэл юм.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуулийн орчинд бие махбодын хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэлд өртөгдөх, сургуулиас гэр, гэрээс сургууль явах замдаа хүүхдүүд аюулд өртөх эрсдэл өндөртэй байсаар байна⁹. “Үе тэнгийнхний дарамт гадуурхал, хүчирхийлэл” судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 37.9% нь ямар нэг байдлаар дээрэлхүүлж доромжлуулсан, 40.7% нь бусад хүүхдийг зодуулж, дээрэлхүүлж байхыг харсан, 84.2% нь дарамтлуулж, шоовдорлуулан хэнд хандахаа мэддэггүй гэж хариулснаас үзэхэд сургуулийн орчинд дахь хүчирхийллийн үйлдлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд багагүй хэмжээнд өртөж, ялгаварлан гадуурхалтад өртөж байгааг дахин илтгэж байна¹⁰.

Тохиолдол 7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг биеийн тамирын хичээл орох үеэр хувцас солих үед ангийн хөвгүүн бэлэг эрхтнээс нь базаж, үнэхээр чамд байдаг уу гэж асуусан байна¹¹.

Эцэг эхийн харилцаа, хандлага, нөхцөл байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6.5.2-т заасны дагуу гэр бүлийн гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх

⁸ “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, (2020), “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” чанарын судалгааны тайлан. Монгол Улс, Улаанбаатар хот.

⁹ Б.Энхболд нар (2019). *Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт гэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ, бодлогын судалгааны тайлан.* Монгол Улс, Улаанбаатар хот. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн газрын хувьд авч үзвэл өөрийн амьдардаг гэрт (38.2%), бусдын гэрт (30.9%), гудамж талбай (2.9%), албан газар (1.5%), сургуулийн орчинд (1.5%), зочид буудалд (11.7%), хөдөө хээр (13.2%) тус тус байна.

ХИС (2017). “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгааны тайлан. 8 дахь тал. Монгол Улс, Улаанбаатар хот. Өнгөрсөн онд ямар нэг байдлаар дээрэлхүүлж доромжлуулсан (37.9%), бусад хүүхдийг зодуулж дээрэлхүүлж байхыг харсан (40.7%), .. цахимаар бусдаас доромжилсон өнгө аястай захиа, зурвал хүлээн авсан (11.7%), ... насанд хүрсэн хүн интернетээр холбогдох бэлгийн харилцааны талаар охидтой ярилцахыг оролдсон (4.1%).

¹⁰ БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн Сан болон бусад (2007). *Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг арилгах зам судалгааны тайлан.* 68 дахь тал. Монгол Улс, Улаанбаатар хот. 6-11-р ангийн сурагчдын 98.6 хувь нь сургуулийн орчинд ямар нэгэн төрлийн хүчирхийлэлд өртдөг ба үйлдэж буй субъект нь юуны өмнө үе тэнгийнхэн нь байдаг.

¹¹ Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл (2021)

чадваржуулах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийвэл ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр болно.

Хүүхэд боловсрол эзэмшихэд эцэг эхийн үүрэг, тэдний хайр, халамж, оролцоо, дэмжлэг хамгийн чухал үр нөлөөтэй. Манай улсын хувьд гэр бүлийн хүрээн дэх архидалтаас үүдэлтэй хэрүүл зодоон, байнгын дарамт нь хүүхдийн хичээл хийх нөхцөлийг бууруулах, цаашлаад хүүхдийн тайван амгалан орчинд амьдрах нөхцөлийг алдагдуулж, айдас, түгшүүр, сэтгэл санааны дарамтад оруулж, дутуу дулимагийн мэдрэмжийг насан туршид нь үлдээдэг. Нөгөө талаас эцэг, эх, асран хамгаалагчдын хүүхдийнхээ хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, хоёрдогч хүндрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрт үед нь сэргээн засах эмчилгээ, үйлчилгээнд явуулах, тэр дундаа боловсролд хамруулах үйл ажиллагаа учир дутагдалтай байна.

Хүүхдээ сэргээн засах үйлчилгээнд явуулна гэдэг нь зөвхөн эрүүл мэндийн сэргээн засах үйлчилгээ бус, нийгмийн, боловсролын сэргээн засалтын үйлчилгээ нэн чухал юм. Хүүхэд багаасаа буюу 0-6 нас хүртлээ нийгмийн харилцаанд орж, найз нөхөдтэйгээ тоглох, үерхэж, нөхөрлөх, инээж, уйлах явцдаа бусадтай харилцах зан үйл, өөрийгөө илэрхийлэх, өөртөө итгэлтэй байх, өөрийгөө зохицуулж суралцах, улмаар ирээдүйд бие даан суралцах чадварт суралцдаг байна. Үүнд эцэг эхчүүдийн мэдлэг, мэдээлэлтэй байх, хүүхдийнхээ боловсролын үйл ажиллагаанд зарцуулах оролцоо чухал бөгөөд тэр дундаа эцэг эхчүүдийн хүүхдээ сэдэлжүүлэх арга зам буюу ялгаварлан гадуурхалтаас ангид байх арга барил хамгийн чухал үр нөлөөтэй юм.

Тохиолдол 8. Би багадаа хөл бөмбөгийн бөмбөг өшиглөхийг маш их хүсдэг байлаа. Ээж маань намайг бэртэж гэмтэнэ гээд хэзээ ч хүүхдүүдтэй хамт хөл бөмбөг тоглуулдаггүй байсан¹².

Ээжийн хувьд хүүхдээ аливаа осол аюулаас хамгаалах нь зөв. Тэгэхдээ хүүхдийнхээ хүсэл мөрөөдлийг сонсож, хийж чадах боломж нөөцөд нь тулгуурласан үйл ажиллагаанд аль болох татан оролцуулж байсан бол насанд хүрсэн хойноо орон зайн мэдрэмжтэй байх, бусадтайгаа харилцах чадварт суралцах бүх боломжууд нээгдэх боломжтой байсан юм. Өөрөөр хэлбэл, насанд хүрэгчид, эцэг эхчүүдийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ үйлдлийг хязгаарлаж байгаа нь тэднийг “хийж чадахгүй” гэсэн хувь хүний эрхийг хөндсөн ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр гэдгийг ойлгох хэрэгтэй байна.

¹² Харааны бэрхшээлтэй нэгэн залуугийн ярианаас (2021)

Тохиолдол 9. Эцэг эхчүүд хүүхдийнх нь ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд явахад их дургүйцдэг¹³.

Харамсалтай нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургууль, цэцэрлэгт суралцахад үе тэнгийн найз нөхөд, сургуулийн хамт олноос илүү зарим эцэг эхчүүд дургүйцэж, хүүхдийнх нь хичээл сурлагад саад болох, сурлагад муугаар нөлөөлөх, өвчтэй зовлонтой хүнээс халдвартай өвчин авч эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж, өвчин хүрнэ гэж харан хүүхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хамт суралцуулахгүй байх тал дээр асуудал үүсгэдэг байна. Хөгжлийн бэрхшээл бол халдварт өвчин биш юм. Эдгээр эцэг эхчүүдийн ёс зүйн хувьд зүй бус байр суурь үзэл хандлага нь эсрэгээрээ хүүхдийнх нь хүмүүнлэг байх, хүн хүндээ хайртай байх зан үйл, дадал, хүмүүжилд сөргөөр нөлөөлж болох юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг өөрөөсөө ялгаатай мэтээр харж, гадуурхаж, шоглох, доромжлох, зүй бус харилцах үзэгдлийг анги хамт олондоо харуулах, ирээдүйд нийгмийн зүгээс үзүүлэх ялгаварлан гадуурхалтыг бий болгох үндсийг тавьж байгаа хэрэг юм.

Цөөхөн хэдэн эцэг эхчүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хүүхдийнх нь ангид суралцахад таатай хүлээж авдаг байна. Энэхүү жишээнээс та бүхэн суралцаж чадаж байвал биднээс ялгаатай хүнийг байгаагаар нь хүлээн авч, өөрийгөө өөрчлөх гэж оролддог хүний эрхэд суурилсан хандлага төлөвших учиртай юм шүү.

Тохиолдол 10. Хүүхдийн чинь ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч байгаа бол та их азтай гэсэн үг шүү. Хүүдээ (охиндоо) ялгаатай байдлын талаар илүү сайн ойлгуулахад, бусдыг хайрлах, хэнийг ч ялгалгүй тоглож, хамтдаа суралцаж хөгждөг нэгэн болоход нь туслаарай. Бид л хүүхдүүддээ зааж сургах ёстой шүү. Миний охин 4 настай. Ялгаатай нэгнийг хараад айгаад байдаг байсан юм. Би үргэлж тайлбарлаж өгнө. Хүн бүхэн адилхан алхдаггүй, хүн бүрэн ярьдаггүй гээд л... ойлгох хэмжээнд нь чадлаараа ярилцана. Одоо охин минь айгаад байсан ахруугаа хараад инээмсэглэдэг болсон¹⁴.

Багшийн харилцаа, хандлага, ур чадварын нөхцөл байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6.3.3-т заасны дагуу хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс

¹³ Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл (2021)

¹⁴ Facebook page. Destiny Duuree. 2021.09.03-ны өдрийн 17.12 цагт фостлосон мэдээлэл. Албан ёсны зөвшөөрөл авсан болно.

татгалзах, сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, ялгавартай хандах нь ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр болно.

Багш хүний хандлага, зан үйл, арга, байр байдал, дадал, бодол санаа нь хүүхдэд хүний эрх тэгш байдлын талаарх ойлголт төлөвшихөд чухал нөлөөтэй. Багш нар хүний эрхэд суурилсан хандлага, мэдрэмжтэй, багшлах үйл ажиллагаандаа сурагчдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах арга барилд суралцахын тулд багшаар бэлтгэгдэж байхдаа ч, ажил дээр гарсныхаа дараа ч энэ талын сургалтад тогтмол хамрагдаж байх нь чухал байна¹⁵. Багш хичээл, сургалтын үйл ажиллагаа, сурагчидтайгаа харьцах харилцаа, үүрэг даалгаварыг зохион байгуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эмзэг байдлыг хөндөх, эрхэд нь халдах, ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах тал дээр анхаарах нь чухал.

Тохиолдол 11. Нэгэн багш саажилттай, явахад хүндрэлтэй охиныг бие засуулах үүрэг даалгаврыг ангийн хөвгүүнд даалгажээ¹⁶.

Нөгөө талаас анги хамт олны уур амьсгалыг эерэгжүүлэх, сурагчид өөр хоорондын ялгаатай байдлыг харилцан хүлээн зөвшөөрдөг, нэг нэгэндээ тусалж, дэмждэг зан үйлийг дадал болгож хэвшүүлэхэд багшийн зүгээс үзүүлэх нөлөөлөл, мэдээллийн ажил чухал ач холбогдолтой юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллаж буй багш нь суралцагчийн эцэг эхийг нас, яс үндэс, боловсрол, шашин шүтлэг, улс төрийн үзэл, амьдралын нөхцөлөөр үл ялгаварлан, боловсролын харилцаанд гэр бүл, эцэг эхийг нээлттэй тэгш оролцуулах, суралцагчийн боловсрол эзэмших, хөгжих боломжийг хөгжүүлэх үүргийг эцэг эхийн өмнө хариуцаж, тохирсон арга зүйн туслалцааг эцэг эх, асран хамгаалагчид тогтмол үзүүлэх, эцэг эхийн санал, шаардлагыг хүлээн авч, хүүхдэд нь хамаарах асуудлаар эцэг эхэд зөв шаардлага тавих, хамтран ажиллагчдынхаа нас, хүйс, хувийн онцлог, албан тушаал, мэдлэг туршлагаар нь ялгаварлахгүйгээр хүндэтгэлтэй харилцах, сурган хүмүүжүүлэх туршлагаа бусадтай хуваалцан, хувийн болон байгууллагын эрх ашгийг зөв хослуулж, хамт олны эв нэгдлийг дээдлэх, удирдлага, хамт олон, суралцагч, эцэг эх, олон нийтийн зүгээс учруулж

¹⁵ С.Түмэндэлгэр нар (2016). *Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ*. Монгол Улс, Улаанбаатар хот. Уг судалгаанд хамгийн том багш бэлтгэдэг сургууль болох Монгол Улсын Боловсролын Их сургууль нь 14 мэргэжлээр 2000 оюутныг бакалаврын төвшинд төгсгөж байгаа бөгөөд багш бэлтгэх хөтөлбөрт жендэрийн агуулга төдийлөн тусгагдаагүй, сонгон судлахаар заасан боловч сонгон суралцаж байгаа суралцагчдын мэдээлэл байхгүй байгаа талаар дурджээ.

¹⁶ Фокус бүлгийн уулзалтын тэмдэглэлээс (2021)

болзошгүй зүй бус эрсдлээс хамт олны болон өөрийн нэр төрийг хамгаалах үүргийг биелүүлэн ажиллах нь чухал гэжээ¹⁷.

Сургуулийн эрүүл, аюулгүй орчин, дэд бүтцийг бий болгох асуудал, нөхцөл байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6.2-т Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг

- бүрдүүлээгүй байх,
- бүрдүүлэхээс татгалзах,
- нийгмийн үйлчилгээг бусдын адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах

6.3.1-т нийтийн тээврээр зорчих, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлээгүй байх, 6.3.2-т хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлээгүй байх, 6.7-т төрийн байгууллага, иргэн хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн оролцохыг баталгаажуулах зорилгоор тэднийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ гэж ялгаварлан гадуурхалтын эсрэг заалтуудыг тус тус заасан байна.

Ганцхан хөгжлийн бэрхшээлтэй хүн гэлтгүй бүх хүнд хүртээмжтэй байдлаар сургуулийн эрүүл, аюулгүй орчин, дэд бүтцийн хүртээмжийг бий болгох шаардлагатай байна. Тухайлбал, ахмад настан, жирэмсэн эмэгтэй, хүүхдүүд бүх хүн сургуулийн орчинд аюулгүйгээр саадгүй нэвтрэх зорчих боломжтой “Түгээмэл загвар” /хүн бүр ашиглах боломжтой хэв маягаар төлөвлөсөн загвар/-т тулгуурласан байх нь хүний эрхэд суурилсан, ялгаварлан гадуурхалтын эсрэг хандлага юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсэг “Түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, програм, орчин болон үйлчилгээний хэв маягийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. Энэ талаар Хүүхэд хамгааллын тухай хууль, Боловсролын тухай хууль, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2018 оны А/243 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрмээр зааж өгсөн байдаг. Мөн 2018 оны 7 дугаар сард АХБ нь Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх дэлхийн дээд хэмжээний уулзалтад оролцож, тэгш хамруулсан хөгжлийг дэмжих чиглэлээр хэд хэдэн үүрэг амлалт авсны нэг нь хөгжлийн

¹⁷ ХНХЯ, DB>S, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, НЛМ Норвегийн тусламжийн байгууллага (2021). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх*. Монгол Улс, Улаанбаатар хот.

бэрхшээлтэй суралцагчдад зориулсан хэрэглэхэд дөхөм материалууд болон сургалтын аргуудын чанар, сонголт, хамрах хүрээг өргөжүүлэхийн тулд түгээмэл загвараар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцахад шаардлагатай материаллаг орчныг илүү хүртээмжтэй болгох явдлыг тунхаглажээ (ADB, 2020).

Тохиолдол 12. Би хүүхдээ танай сургуульд явуулах гэсэн юм аа. Гэхдээ манай тэргэнцэр хэрэглэдэг юм. Харамсалтай нь манайд цахилгаан шат байхгүй тул танай хүүхдийг 2, 3 давхар луу зөөх хэцүү байна. Танай хүүхдийг сургуульд сургах боломж хүндрэлтэй байна¹⁸.

Сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, мэргэжилтнүүдийн хандлагын асуудал, нөхцөл байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд хамруулахад цэцэрлэг, сургуулиудын удирдлага, нийгмийн ажилтан, мэргэжилтнүүдийн үүрэг оролцоо маш чухал билээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах багш, ажилтныг сонгон шалгаруулахдаа хүний эрхэд суурилсан хандлага, байр суурийг харах, багш, ажилчдадаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүйд сургахад анхаарч мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, аль болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг элсүүлж, тэдэнд тохирсон тохируулгатай орчин, дэд бүтэц, түгээмэл загварыг бий болгох, хичээл, сургалтын үйл ажиллагааг сайжруулахад санхүүжилт гаргах, олон талт сургалт, хүмүүжлийн ажлыг зохион байгуулах, сургалтын үйл ажиллагааны дэвшилтэд арга, хэлбэрийг турших, нэвтрүүлэхэд санаачилгатай ажиллах нэн шаардлагатай байна. Ялангуяа бүх эцэг эхчүүд, асран хамгаалагч, иргэдэд нийтийн боловсрол олгох, хөгжлийн бэрхшээлийн талаар олон нийтийн эерэг хандлагыг төлөвшүүлэх, суралцагчийг сургуулийн ойр орчин, гэрээс сургууль, сургуулиас гэр хүртэлх зам, цахим орчинд ялгаварлан гадуурхалтад өртөх, гэмт хэрэг, зөрчил, аливаа хүчирхийлэл зэрэг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон гэр бүл, асран хамгаалагчдад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээнд чиглүүлэх, холбон зуучлах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах нь чухал байна. Зарим сургуулиудын удирдлагууд өөрт байгаа санхүүгийн нөөц боломжид тулгуурлан тодорхой хэмжээний санхүүжилтийг хүүхэд хамгааллын зардалд зарцуулдаг байна.

Тохиолдол 13. Нэгэн сургуулийн удирдлага хүүхэд хамгааллын үйлчилгээний зардалд зориулж нийгмийн

¹⁸ Уулзалтад оролцогчдын ярилцлагын тэмдэглэлээс (2021)

ажилтандаа сард унааны зардал болох 5000 төгрөгийг өгдөг байна¹⁹.

“Далайд дусал нэмэр” гэдэг шиг аливаа хүндрэл бэрхшээлийг даван туулахад сэтгэл, зүтгэл байвал ямар нэгэн ажлыг явуулж болдгийн жишээний нэг юм.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлж бодлогын баримт бичгүүд Алсын хараа-2050, Тогтвортой хөгжлийн зорилт-2030, салбарын тайлан мэдээлэл болох Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангаас гаргасан “Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг арилгах зам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Дэлхийн банкны Монгол Улсын бага боловсролын салбарын судалгаа тайлан (2019), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, НЛМ Норвегийн тусламжийн байгууллагын хамтарсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх” тайлан (2021), донор байгууллагуудын Азийн хөгжлийн банкны “Монгол Улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь” (2020), Олон улсын эдийн засаг, хамтын ажиллагааны нийгэмлэгийн “How’s Life? 2020: Measuring Well-being-Highlights” (2020), Японы хүүхдийг ивээх сангийн “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгааны тайлан (2017), ЮНЕСКО болон бусад хамтрагч байгууллагын гаргасан “Хүмүүс, гараг дэлхийн төлөө боловсрол: Бүх нийтийн төлөө тогтвортой ирээдүйг бүтээх нь” боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлангийн хураангуй (2016), иргэний нийгмийн байгууллагуудын тайлан мэдээлэл, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслээс гаргасан “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” чанарын судалгааны тайлан (2020), “Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аргачлал сэдэвт гарын авлага (2020), эрдэмтэн судлаачид, тухайлбал, “Developmental research, public policy, and the ecology of childhood” (Bronfenbrenner, U., 1974), “Toward an experimental ecology of human development” (Bronfenbrenner, U., 1977), Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага сэдэвт лекцийн материал (Х.Сансармаа, 2021), “Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ” (С.Түмэндэлгэр нар, 2016), “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт гэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ, бодлогын судалгааны тайлан” (Б.Энхболд нар, 2019), болон иргэн н.Дүүрээгийн facebook фост зэрэг нийт 20 судалгаануудын тайлан, мэдээлэлд дүн шинжилгээ хийж энэхүү судалгааны ажлыг бичлээ. Дүн шинжилгээ болон фокус бүлгээр ярилцсан тохиолдол, оролцогчдын ярилцлагын тэмдэглэлээс дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

¹⁹ Уулзалтад оролцогчдын ярилцлагын тэмдэглэлээс (2021)

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг хангах, тэднийг боловсролоос ялгаварлан гадуурхалтад өртүүлэхгүй байхад чиглэсэн хууль эрх зүйн зүйл заалт, дүрэм журмууд байгаа хэдий ч хэрэгжилт хангалтгүй, санхүүжүүлэх тогтолцоо тодорхой бус байна.

Сургуульд хамрагдалтын дэмжих зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй, сургуулийн удирдлага, багш, ажилтнуудын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага мэдлэг дутмаг, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хичээлийн хэрэглэгдэхүүн, техник тоног төхөөрөмж хангалтгүй, гудамж талбай, сургуулийн орчны хүртээмжгүй байдал зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд хамрагдахад саад учруулж байна. Ганцхан хөгжлийн бэрхшээлтэй хүн гэлтгүй бүх хүнд хүртээмжтэй байдлаар шийдэх “Түгээмэл загвар” /хүн бүр ашиглах боломжтой хэв маягаар төлөвлөсөн загвар/ бий болохгүй байна.

Мөн боловсролын чанарын үнэлгээний судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хамруулж судалдаггүй нь нэг талаас эдгээр хүүхдүүдийн чанартай боловсрол эзэмших асуудал тодорхой бус, нөгөө талаас хүний эрхэд суурилсан хандлага байхгүй байгааг илтгэж байна.

Олон нийтийн тэгш хамруулах үзэл санааны ойлголтын зөрүүтэй байдал, сургуулийн удирдлага, ажилтнуудын хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт дутмаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчид, гэр бүлийн гишүүдийн хүүхдийнхээ боловсролд анхаарах, нийгмийн харилцаанд оролцуулах, хөгжүүлэх, чадваржуулах үйлчилгээнд хамруулах, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, хоёрдогч хүндрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрт үед нь сэргээн засах эмчилгээ, үйлчилгээнд явуулах, тэр дундаа боловсролд хамруулах талаарх мэдлэг ойлголт дутмаг, хандлага сул байна.

Багш нарын хүний эрхэд суурилсан хандлага, мэдрэмж, багшлах үйл ажиллагаандаа сурагчдын ялгаатай байдлыг харгалзан авч үздэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах арга барил учир дутагдалтай байна. Сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулгад хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг төлөвшүүлэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах асуудал бүрэн тусгагдахгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй анги хамт олны өөр хоорондын ялгаатай байдлыг харилцан хүлээн зөвшөөрдөг, нэг нэгэндээ тусалж, дэмждэг зан үйл, дадал хэвшил хангалтгүй байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг хангах, тэднийг боловсролоос ялгаварлан гадуурхалтад өртүүлэхгүй байхад чиглэсэн хууль эрх зүйн зүйл заалтуудыг хэрэгжүүлэх механизм, дүрэм,

журмыг тодорхой болгох, тайлбарлах, санхүүжүүлэх тогтолцоог сайжруулах, хуулийн хэрэгжилтийг хангахад салбар хоорондын уялдаа, холбоог сайжруулах

- Олон нийтийн тэгш хамруулах үзэл санааны ойлголтын зөрүүтэй байдлыг арилгахад чиглэсэн сургалт зохион байгуулах
- Сургуульд хамрагдалтын дэмжих зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах
- Сургуулийн удирдлага, ажилтнуудын хууль эрх зүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролоос ялгаварлан гадуурхалтын талаарх ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх
- Сургуулийн удирдлага, ажилтнуудын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг сайжруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хичээлийн хэрэглэгдэхүүн, техник тоног төхөөрөмжийг сайжруулах
- Гудамж талбай, сургуулийн орчны хүртээмжийг нэмэгдүүлэх
- Боловсролын үнэлгээний төвөөс явуулдаг боловсролын чанарын үнэлгээний судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хамруулан судлах
- Анги хамт олон, сурагчдын хүний ялгаатай байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх
- Сургуулийн орчинд үе тэнгийнхний дарамт, хүчирхийлэл бий болгохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийн хүүхдээ боловсролд хамруулах, хөгжүүлэх чадваржуулах олон талт үйлчилгээнд хамруулахад чиглэсэн мэдлэг, ойлголт өгөх, дэмжлэг үзүүлэх
- Багшийн харилцаа, хандлага, зан үйл, арга, байр байдал, дадал, бодол санааг хүний эрхэд суурилсан хандлагаар хөгжүүлэх, сургалтыг тогтмол зохион байгуулах
- Ганцхан хөгжлийн бэрхшээлтэй хүн гэлтгүй бүх хүнд хүртээмжтэй байдлаар сургуулийн эрүүл, аюулгүй орчин, дэд бүтцийн хүртээмжийг (түгээмэл загвар) бий болгох
- Сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулгад хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг төлөвшүүлэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах агуулга, арга зүйг тусгах

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БСШУСЯ- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

БХ- Боловсролын хүрээлэн

БҮТ- Боловсролын үнэлгээний төв

ДЭМБ- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ДНБ- Дотоодын нийт бүтээгдэхүүн

ЕБС- Ерөнхий боловсролын сургууль

МУБИС- Монгол Улсын Боловсролын Их Сургууль

СӨБС- МУБИС-ын Сургуулийн өмнө боловсролын салбар сургууль

НХУС- МУБИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны салбар сургууль

БУС- МУБИС-ийн Байгалийн ухааны салбар сургууль

БТС- МУБИС-ийн Биеийн тамирын салбар сургууль

НҮБ- Нэгдсэн үндэсний байгууллага

ТББ- Төрийн бус байгууллага

ҮСХ- Үндэсний Статистикийн хороо

ХНХЯ- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

ХБХХЕГ- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

ADP- Asian Development Poundation

OECD- Organisation for Economic Co-operation and Development

GPE- Global Partnership for Education

WB- The world bank

UNESCO- United Nations Educational, Scientific and Cultural Organization

UNGEI- United Nations Girls' Education Initiative

GEMR- Global Education Monitoring Report

SDG- Sustainable Development Goals

JFPR- Japan Fund for Poverty Reduction

JICA- Japan International Cooperation Agency

IRIM- Хараат бус судалгааны төв ТББ

PISA- Programme for International Student Assessment

PIRLS- Progress in International Reading Literacy Study

TIMSS- Trends in International Mathematics and Science Study

RS- Resilient students

CBR- Matrix- Towards Community-based Inclusive Development Matrix

ХОТСЗ- Хамт олонд түшиглэн сэргээн засах

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал нь сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гаргах, хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодын шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршил өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн цогц юм²⁰.

Эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхэд гэдэг нь эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал хөгжих хэвийн орчин нь алслагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг хэлнэ²¹.

Хүний эрх нь хувь хүн болон нийгмийн бүлгийн байгалиас заяамал эрхийг зөрчигдөж, алдагдахаас хамгаалах суурь эрхийн баталгааны цогц юм. Эдгээр эрх хүн бүрт тэгш заяагдсан ба өөр хэн нэгэн дэлхийн аль ч хэсэг, ямар ч тохиолдолд, ямар ч шалтгаанаар энэ эрхийг нь зөрчих ёсгүй. Хүний эрхийг салшгүй, хуваагдашгүй, харилцан хамааралтай гэж тодорхойлдог²².

Хүний эрхэд суурилсан хандлага гэдэг нь олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд тулгуурлан хүний эрхийг хамгаалах, дэмжих замаар хүнийг хөгжүүлэх үйл явцын цогц суурь юм. Энэ нь хөгжлийн асуудлаас хамааран үүссэн тэгш бус байдлыг халах, алагчлах байдлыг жигшиж, хөгжлийн үйл явцад саад болох шударга бус эрх мэдлийг зогсооход оршино²³.

Тэгш хамруулан сургах гэдэгт тухайн насны бүх суралцагчдыг эрх тэгшээр хамтдаа суралцах туршлагатай болгож, тэдний давуу тал болон тавигдах шаардлагад хамгийн дээд зэргээр тохирсон орчинг бий болгож үйлчилнэ гэсэн алсын харааг хэрэгжүүлэхэд учрах саад тотгорыг даван туулахын тулд боловсролын агуулга, заах арга, хандлага-арга зүй, бүтэц, стратегидаа тодруулга

²⁰Бүх нийт боловсролын төлөө ! Иргэний нийгмийн үндэсний эвсэл (2020b). *Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аргачлал: Гарын авлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.

²¹ Бүх нийт боловсролын төлөө ! Иргэний нийгмийн үндэсний эвсэл (2020b). *Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аргачлал: Гарын авлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.

²² Бүх нийт боловсролын төлөө ! Иргэний нийгмийн үндэсний эвсэл (2020b). *Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аргачлал: Гарын авлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.

²³ Бүх нийт боловсролын төлөө ! Иргэний нийгмийн үндэсний эвсэл (2020b). *Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аргачлал: Гарын авлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.

өөрчлөлт, цогц өөрчлөлт оруулах замаар тогтолцооны шинэчлэл хийх үйл явцыг багтаана²⁴.

Тэгш хамруулах боловсрол (inclusive education) гэдэг нь бүх суралцагчдын нийгэм, соёл, боловсролын үйл ажиллагаан дахь тэгш оролцоог хангах, боловсролын гаднах болон доторх бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг бууруулах замаар сурагч бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үйлчилгээг хүргэх үйл явц юм²⁵.

Маргиналчлагдсан бүлэг гэж нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэйгээр урт хугацаанд нийгэм эдийн засгийн статусын хувьд гадуурхагдаж, боловсролын бодлого төлөвлөлтийн хийдлийн улмаас сурч боловсрох эрх нь зөрчигдсөн бүлэг. Энэхүү судалгаанд жендерт суурилсан хүчирхийллийн хохирогч бүлгийн хүүхдүүдийг авч үзсэн болно²⁶.

Үе тэнгийн дарамт дээрэлхэлт гэж жендерт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд, нийгмийн гарал үүсэл, статусаас хамааран ялгаварлах, гадуурхах, шоглох, заналхийлэх, цохих, тохуурхах, эд зүйлсийг нь хулгайлах шууд үйлдэл болон нэгнийхээ талаар бусдад мэдэгдэхийг хүсдэггүй нууц болон худал, үндэслэлгүй цуу яриа тарааж тухайн сурагчийг нийгмээс тусгаарлагдах нөлөөлөх шууд бус үйлдлүүд орно²⁷.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан, 18 нас хүрээгүй хүн бүрийг хамруулж ойлгоно (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1, Хүүхдийн эрхийн тухай конвенц).

²⁴ “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвсэл (2020). *Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд: чанарын судалгааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.

²⁵ “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвсэл (2020). *Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд: чанарын судалгааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.

²⁶ “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвсэл (2020). *Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд: чанарын судалгааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.

²⁷ “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвсэл (2020). *Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд: чанарын судалгааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.

Гадуурхах гэдэгт шууд болон шууд бусаар ямар нэгэн хэлбэрийн боловсрол эзэмшүүлэхээс татгалзах эсвэл элсүүлэхгүй байхыг хориглоно²⁸.

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгаанд оролцогч талууд, судалгааны арга, судлах зүйл

Хүснэгт 2. Нийгмийн дэд бүтцүүдэд хамаарах нийгмийн институт

ЗАГВАРЫН ЖАГСААЛТ

Загвар 1. Анагаах ухааны загвар ба нийгмийн загварын ялгаа

Загвар 2. Нийгэм-орчны саад бэрхшээл

Загвар 3. Нийгмийн загвар

Загвар 4. CBR матриц

Загвар 5. Эрхийг хүндэтгэх ялгаа

Загвар 6. Бронфенбреннерийн анх санал болгосон экологийн системийн үлгэрчилсэн загвар

²⁸ “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвсэл (2020). *Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд: чанарын судалгааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.

ХАВСРАЛТ

Хавсралт 1

Уулзалт, ярилцлагын асуултын чиглэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын ялгаварлан гадуурхалтад өртөж буй нөхцөл байдал, цаашид шийдвэрлэх арга зам, хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал солилцох зорилгоор энэхүү уулзалт, ярилцлагыг зохион байгуулж байна.

Тухайн судалгааг ХБХХЕГ-ын хөгжлийн бэрхшээлийн судалгаа, эрдэм шинжилгээ хариуцсан мэргэжилтэн удирдан зохион байгуулах юм. Ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэйгээр сургуулийн болон цахим орчинд бусдын зүгээс бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн, улмаар сургуульд завсардах эрсдэлд өртсөн, суралцах эрх нь хязгаарлагдсан, огт суралцаж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамааруулж судална.

ЖИЧ: Судалгаанд оролцогчийн өгсөн мэдээллийг Монгол Улсын хувь хүний нууцыг хадгалах хуулийн дагуу чандлан хадгална.

Тэмдэглэл хөтлөх хуудас

(Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх хамгаалал, хөгжлийн чиглэлээр ажилладаг ТББ, мэргэжилтэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, иргэд)

Ярилцлагын тэмдэглэлийн дугаар:

Ярилцлага хөтөлсөн судлаач:

Ярилцлага хийсэн огноо:

А. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмшихэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл?

1. Сургалтын хөтөлбөр (агуулга)-ийн хүрээнд:
2. Сурагчийг үнэлэх аргачлал, арга зүйд: ...
3. Сурах бичгийн агуулгын хүрээнд:
4. Багшийн харилцаа, заах арга арга зүйн хүрээнд:
5. Хичээлийн хэрэглэгдэхүүний хүрээнд:
6. Багшийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх ажлын хүрээнд:

7. Сургуулийн аюулгүй орчны хүрээнд (тохируулгатай орчин, түгээмэл загвар):
8. Гудамж талбай, хүүхэд гэрлүүгээ явах замд:
9. Улсаас төсөвлөж буй санхүүжилтийн хүрээнд:
10. Ялгаварлан гадуурхалтаас ангид байлгахад чиглэсэн урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны хүрээнд:
11. Бусад:

В. Тэгш хамруулах боловсролын зарчмын хүрээнд авч хэрэгжүүлж буй холбогдох хууль эрх зүйн хүрээнд гарсан бодлогын баримт бичиг, дүрэм, журмын хэрэгжилтийг хангахад учирч буй саад тотгор:

.....

С. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах ажлыг эрчимжүүлэх, холбогдох хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг сайжруулах, зохицуулах арга зам:

.....

СУДАЛГААНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА!

Хавсралт 2

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 45.1 дэх заалт²⁹.

- Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан нь хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь доромжлох, тохуурхах, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл, эцэг эхийг гадуурхах, олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаар буруу ойлголт төрүүлэхүйц мэдээлэл, зар сурталчилгаа явуулах, соёл урлагийн бүтээл хийх, хүний сүсэг бишрэл, итгэл үнэмшилд суурилан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд халдсан аливаа зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх чадваржуулах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийх.

6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах

- 6.1.Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.
- 6.2.Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байх, бүрдүүлэхээс татгалзах, нийгмийн үйлчилгээг бусдын адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ.
- 6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараах үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:
 - 6.3.1.нийтийн тээврээр зорчих, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлээгүй байх;
 - 6.3.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлээгүй байх;
 - 6.3.3.хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, ялгавартай хандах;
 - 6.3.4.хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгааны улмаас зээл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

²⁹ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016 он

- 6.3.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн үржихүйн эрхийг өөрийн нь зөвшөөрөлгүйгээр хязгаарлах;
- 6.3.6.төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзах, зайлсхийх, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байх.
- 6.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараах үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:
 - 6.4.1.ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах, сонгон шалгаруулалтад тэнцсэн хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ажилд авахаас татгалзах;
 - 6.4.2.хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний албан тушаал ахих, дэвших боломжийг хязгаарлах;
 - 6.4.3.байгууллага, аж ахуйн нэгж нь ажиллагсдыг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварласан дүрэм, журам, удирдлагын арга барилыг хэрэглэх, ашиглах;
 - 6.4.4.гэр бүлийн гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хүнийг ажилд авахаас татгалзах, чөлөөлөх, бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг нь хязгаарлах;
 - 6.4.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдлэг ур чадвар, онцлогт тохирсон ажлын байрыг зохион байгуулахаас татгалзах, цалин хөлсийг ялгавартай тогтоох;
 - 6.4.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирсон ажлын байрны тохирох хэрэглэгдэхүүн бий болгохгүй байх.
- 6.5.Дараах үйлдлийг бусад ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:
 - 6.5.1.хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь доромжлох, тохуурхах, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл, эцэг эхийг гадуурхах, олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаар буруу ойлголт төрүүлэхүйц мэдээлэл, зар сурталчилгаа явуулах, соёл урлагийн бүтээл хийх, хүний сүсэг бишрэл, итгэл үнэмшилд суурилан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд халдсан аливаа зөвлөгөө өгөх;
 - 6.5.2.гэр бүлийн гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх чадваржуулах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийх;
 - 6.5.3.хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хүнийг үр хүүхдээ асрамжид авах эрхийг хязгаарлах.
- 6.6.Төрөөс хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс нь

хамгаалсан нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- 6.7.Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн оролцохыг баталгаажуулах зорилгоор тэднийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.
- 6.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралд тэгш оролцох эрхийг нь бодитой хангах зорилгоор онцлогт нь тохируулан авч хэрэгжүүлж байгаа тусгай арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

44 дүгээр зүйл. Гомдол, нэхэмжлэл гаргах

- 44.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хуульд заасан эрх нь зөрчигдсөн гэж үзвэл иргэн, хуулийн этгээдээс зөрчлийг арилгуулахыг шаардах, холбогдох хуульд заасны дагуу гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй.
- 44.2.Иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хуульд заасан эрхийг хязгаарласан, ялгаварлан гадуурхах үйл ажиллагааг явуулсан гэж үзвэл хөндөгдсөн эрхээ хамгаалуулахаар гомдол гаргах эрхээ шууд болон төлөөллөөрөө дамжуулан хэрэгжүүлнэ.


45 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 45.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.
- 45.1.1.энэ хуулийн 6.5.1, 6.5.2-т заасан зөрчил гаргасан хувь хүнийг, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтад 14 хоногоос доошгүй хугацаагаар хамруулна.
- 45.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд гэм хор, хохирол, хор уршиг учирсан бол буруутай этгээдээр холбогдох хуульд заасны дагуу хохирлыг нөхөн төлүүлнэ.

Хавсралт 3

Хүүхдийн хөгжилд хүүхдийн хүрээлж байгаа нийгмийн орчин нөлөөлдгийг Ури Бронфенбреннерийн “Экологийн тогтолцооны онол [ecological theory]”-оор тайлбарлаж болох юм. Энэхүү онолоор хүний хөгжил нь түүний хүрээлж буй нийгмийн хүрээллүүд болох экологийн микросистем, мезосистем, экзосистем, макросистем гэсэн нийгмийн дэд бүтцүүдээс бүрдэх юм (Загвар 6) (Bronfenbrenner, 1974, 1977, 1995)³⁰.

Загвар 6. Бронфенбреннерийн анх санал болгосон экологийн системийн үлгэрчилсэн загвар



Эх сурвалж: Bronfenbrenner, U., & Evans, G.W. (2000)³¹.

Эдгээр нийгмийн дэд бүтцүүдэд дараах нийгмийн институтийг багтааж ойлгож болохыг хүснэгт 2-д үзүүлэв.

Хүснэгт 2. Нийгмийн дэд бүтцүүдэд хамаарах нийгмийн институт

Микросистем	Мезосистем	Экзосистем	Макросистем
Хүүхдийг хүрээлж буй анхдагч орчин болох	Хүүхдийн амьдралд тодорхой үүрэг хүлээж	Эцэг эхийн ажлын газар, хөрш, олон	Тухайн улсын соёл, үнэт зүйлс, нөөц

³⁰ Bronfenbrenner, U. (1974). Developmental research, public policy, and the ecology of childhood. *Child development*, 45(1), 1-5.

³¹ Bronfenbrenner, U. (1977). Toward an experimental ecology of human development. *American psychologist*, 32(7), 513.

гэр бүл, оршин амьдарч буй байршил, хороо	буй цэцэрлэг, хоорондын харилцан үйлчлэл	нийтийн мэдээллийн хэрэгсэл, засгийн газрын агентлагууд, бараа, үйлчилгээний хуваарилалт, харилцах холбоо, тээврийн хэрэгслүүд гэх мэт хүүхдэд хамааралтай боловч шууд харилцаанд ордоггүй нийгмийн томоохон институтууд, албан бус сүлжээнүүд	боломж, эдийн засаг, нийгэм, боловсрол, хууль эрх зүй, улс төр
---	--	--	--

Эх сурвалж: Bronfenbrenner, U., & Evans, G.W. (2000)³²

Экологийн тогтолцооны онолын дагуу хүний хөгжил нь өсөн нэмэгдэж буй хүний организм ба өөрчлөгдөж буй орчны хооронд үүсдэг бөгөөд хөгжлийн явцад нэн даруй тохиргоог хийхийг шаарддаг байна. Ури Бронфенбрэннерийн экологийн онол нь хүний хөгжлийг судлахад хамгийн өргөн хэрэглэгдэг онол болжээ.

³² Bronfenbrenner, U. (1974). Developmental ecology through space and time: A future perspective.

Ашигласан материал:

1. ADB (2020). Монгол Улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь. Монгол Улс: Улаанбаатар хот.
2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
3. БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн Сан болон бусад (2007). *Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг арилгах зам судалгааны тайлан*. 68 дахь тал. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. БСШУСЯ GPE WB (2019). *Монгол Улсын бага боловсролын салбарын судалгаа тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, (2020), *“Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” чанарын судалгааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.
6. Бүх нийт боловсролын төлөө ! Иргэний нийгмийн үндэсний эвсэл (2020b). *Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аргачлал: Гарын авлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.
7. Bronfenbrenner, U. (1974). Developmental research, public policy, and the ecology of childhood. *Child development*, 45(1), 1-5.
8. Bronfenbrenner, U. (1977). Toward an experimental ecology of human development. *American psychologist*, 32(7), 513.
9. Bronfenbrenner, U. (1974). Developmental ecology through space and time: A future perspective.
10. Bronfenbrenner, U., & Evans, G.W. (2000). Developmental science in the 21st century: Emerging questions, theoretical models, research designs and empirical findings. *Social development*, 9(1), 115-125.
11. Bronfenbrenner, U., & Evans, G.W. (2000). Developmental science in the 21st century: Emerging questions, theoretical models, research designs and empirical findings. *Social development*, 9(1), 115-125.
12. OECD (2020). *How's Life? 2020: Measuring Well-being-Highlights*. Paris. Retrieved from <https://www.oecd.org/sdd/How-is-Life-2020-Highlights.pdf>

13. Х.Сансармаа (2021). *Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага сэдэвт лекцийн материал*. Монгол Улс, Улаанбаатар хот.
14. С.Түмэндэлгэр нар (2016). *Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ*. Монгол Улс, Улаанбаатар хот.
15. Тогтвортой хөгжлийн зорилт-2030
16. ХНХЯ, DB>S, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, НЛМ Норвегийн тусламжийн байгууллага (2021). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх*. Монгол Улс, Улаанбаатар хот.
17. ХИС (2017). *“Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгааны тайлан*. 8 дахь тал. Монгол Улс, Улаанбаатар хот.
18. UNESCO SDG GEMR (2016). *Хүмүүс, гараг дэлхийн төлөө боловсрол: Бүх нийтийн төлөө тогтвортой ирээдүйг бүтээх нь. Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлангийн хураангуй*. Монгол Улс, Улаанбаатар хот.
19. Б.Энхболд нар (2019). *Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт гэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ, бодлогын судалгааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.
20. Facebook page. Destiny Duuree. 2021.09.03-ны өдрийн 17.12 цагт фостлосон мэдээлэл. Албан ёсны зөвшөөрөл авсан болно.